



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургууль түүний бүрэлдэхүүн сургуулиудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай

2. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захирал Б.Очирбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000657

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны дүгээр сарын 18-ны өдрийн
25.7 дугаар тогтоолын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУДИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнийн санал
1.Дарханы Технологийн сургууль						
1	Тоёота Дуна, 71-57ДАА, ачааны, хөдөлгүүр - 2000, арлын дугаар - BV102-0102279	1995/2006	180456	5,000,000.00	-	500,000.00
2.Үйлдвэрлэл технологийн сургууль						
1	E50 загварын Ниссан Илгранд, 5059УНО, суудлын, КН-АТЕ50, 9660, АТЕ50032719	2002/2011	181100	15,000,000.00	-	1,000,000.00
Нийт дүн				20,000,000.00	-	1,500,000.00
				(хорин сая)		(нэг сая таван зуун мянга)